



# Урт хугацаат дахин санхүүжилт болон нийлүүлэлтийн сүлжээний санхүүжилтийн талаар

Б.Цэнд-Аюуш  
Мөнгөний бодлогын газар  
МОНГОЛБАНК

Улаанбаатар хот  
2021 он

**Жижиг, дунд үйлдвэрлэл, уул уурхайн бус  
экспортыг дэмжихэд зориулсан урт хугацаат  
(репо) дахин санхүүжилт**

## УРТ ХУГАЦААТ РЕПО АРИЛЖААГ ХЭРЭГЖҮҮЛСНЭЭР:

- Ажлын байрыг дэмжих;
- Санхүүгийн зах зээлд урт хугацаат шинэ хэрэгслийг нэвтрүүлэх;
- Ирээдүйд эдийн засгийг төрөлжүүлэх, хүртээмжтэй өсөлтийг бий болгоход хувь нэмэр оруулах салбарыг хямралд гүнзгий өртөхөөс сэргийлэх зэрэг ач холбогдолтой.

# Хийгдсэн ажлууд

## 1. МӨНГӨНИЙ БОДЛОГЫН ХОРООНЫ ШИЙДВЭР

Мөнгөний бодлогын хорооноос 2020 оны 4 дүгээр улиралд 230 тэрбум төгрөг, 2021 оны 1 дүгээр улиралд 250 тэрбум төгрөг, 2021 оны 2 дугаар улиралд 350 тэрбум төгрөг, 2021 оны 3 дугаар улиралд 250 тэрбум төгрөгийн санхүүжилт олгохоор шийдвэрлэв.

## 2. ХОЛБОГДОХ ЭРХ ЗҮЙН БАРИМТ БИЧИГ

- Төв банкны репо арилжааны журам;
- Долоо хоногоос урт хугацаатай репо арилжааны нэмэлт нөхцөл батлах тухай тушаал;
- Урт хугацаат репо арилжааны хэмжээ, нэмэлт нөхцөлд өөрчлөлт оруулах тухай тушаал;
- Хэвийн зээлээр баталгаажсан үнэт цаас гаргах, репо нөхцөлөөр санхүүжилт олгох ерөнхий гэрээ зэргийг боловсруулав.

# Урт хугацаат репо арилжаагаарх зээлийн нөхцөл

## 1. Хамрагдах салбар

Уул уурхайн бус экспорт; жижиг, дунд үйлдвэрлэл (Иргэд, ААН); үйлчилгээ; боловсруулах үйлдвэрлэл; бөөний болон жижиглэн худалдаа (200 болон түүнээс дээш ажилтантай)-ны салбарууд хамрагдана.




## 2. Зээлийн шинж, чанар

- Зээлийн хүү нь **репо арилжааны хүү+4 нэгж хувиас хэтрэхгүй** байх (Одоогоор 10 хувьд зээл олгоно);
- Зээлийн хугацаа нь **2 жилээс доошгүй** байх;
- Зээлийн дээд хэмжээ хамрагдах боломжтой салбаруудад **3 тэрбум төгрөг хүртэл** байх;
- Харилцагчийн хүсэлтээр үндсэн төлбөрөөс **6-с доошгүй сараар** чөлөөлөх.
- Хөдлөх болон үл хөдлөх хөрөнгө барьцаалах боломжтой байх.
- Зээлийн төлбөрийг төлж барагдуулж чадахуйц бизнесийн үйл ажиллагаатай байх.
- Дахин санхүүжүүлэх зээлийн хувьд зээлийн ангилал 2019 оны эцсийн байдлаар хэвийн байх.
- Монгол улсын хуулийн этгээд байх.

# Урт хугацаат репо арилжааны гүйцэтгэл

(8.31 байдлаар банкуудад 895 тэрбум төгрөг хувиарлаад байна)

Үзүүлэлт (8.31-ний байдлаар)	Зээлийн хүсэлтийн дүн (Тэрбум ₮)	Зээлийн хүсэлтийн тоо	Олгосон зээлийн дүн (Тэрбум ₮)	Олгосон зээлийн тоо	Хадгалсан ажлын байрны тоо
Нийт	947.4	3,738	670.3	2,939	30,283



■ Дахин санхүүжүүлсэн  
■ Шинээр олгосон

■ Улаанбаатар ■ Орон нутаг

■ ЖДҮ ■ УУБ экспорт





# **Нийлүүлэлтийн сүлжээний санхүүжилтийн талаар**

## Нийлүүлэлтийн сүлжээний санхүүжилт (НСС)

- **НСС-нь** авлага, тоног төхөөрөмж, бараа материал, ирээдүйд орж ирэх орлого */авлага/* зэрэг **Хөдлөх хөрөнгө барьцаалан эргэлтийн хөрөнгийн зээл, санхүүжилт авах** үйл ажиллагааны гол бүрэлдэхүүн хэсэг юм.
- НСС нь **авлага, бараа материал** болон сүлжээнд оролцогчдын хоорондын **харилцаа холбоог** ашиглан сүлжээний гишүүдэд санхүүжилт олгох үйл ажиллагаа бөгөөд ингэснээр тэдэнд эргэлтийн хөрөнгө болон бэлэн мөнгөний урсгалаа оновчтой хэмжээнд байлгах боломжийн олгодог.



# НСС-ийн жишээ

## (Жишээнд хийсвэр тооцоолол ашигласан болно)

### Эргэлтийн хөрөнгийн санхүүжилт Жишээ 1: Ханган нийлүүлэгчийн санхүүжилтийн схем



- Сүү ХХК-ний зүгээс банкинд өөрийн ханган нийлүүлэгчдийн талаарх дэлгэрэнгүй мэдээллийг гаргаж өгнө
- Сүү ХХК нь Нийлүүлэгчээс нийлүүлсэн сүүг хүлээн авч 1.0 сая ₮ төлбөр төлөхийг баталгаажуулна (Нийлүүлэгчийн хувьд Авлага үүснэ)
- Сүү ХХК нь 1.0 сая ₮ төлбөрийг Нийлүүлэгчид төлөх тухай мэдээллийг Банкнд хүргүүлэн заасан хугацаанд төлбөр төлөхөө баталгаажуулна.
- Сүү ХХК нь 1.0 сая ₮ төлбөрийг заасан хугацаанд Банк дээр байрших Нийлүүлэгчийн дансанд шилжүүлнэ

- Нийлүүлэгч үлдсэн 200 мянган ₮-өөс хүү шимтгэл хасагдаад үлдсэн дүнг хүлээн авна

- Нийлүүлэгч болон Сүү ХХК нь Банкны KYC/DD шаардлагуудыг хангасан байх шаардлагатай
- Сүү ХХК-ний төлбөр төлөх баталгаажуулалт дээр үндэслэн Банк 800 мянган ₮ (Банк өөрийн бодлогоос хамааран Нийлүүлэгчийн авлагын 90-80 хувьд санхүүжилт олгох) санхүүжилтийг Нийлүүлэгчийн дансанд нэн даруй шилжүүлнэ
- Банкны зүгээс Нийлүүлэгчийн 1.0 сая ₮ авлага дээр барьцааны эрх үүсгэн барьцааны мэдэгдлээ ХХБМБЦМС\*-нд бүртгүүлнэ.
- Сүү ХХК-иас 1.0 сая ₮ төлбөр төлөгдсөний дараа Банкны зүгээс 800 мянган ₮ + зээлийн хүү шимтгэлийг Нийлүүлэгчийн данснаас шууд суутгана

\* - Хөдлөх хөрөнгийн барьцааны мэдэгдлийг бүртгэх цахим мэдээллийн санд

# НСС-ийн жишээ

## Эргэлтийн хөрөнгийн санхүүжилт Жишээ 2: Ханган нийлүүлэгчийн/Худалдан авалтын санхүүжилтийн схем



- E mart-ийн зүгээс банкинд өөрийн ханган нийлүүлэгчдийн талаарх дэлгэрэнгүй мэдээллийг гаргаж өгнө
- E mart нь Сүү ХХК-иас нийлүүлсэн сүүг хүлээн авч 1.0 сая ₮ төлбөр төлөхийг баталгаажуулна (Сүү ХХК-ийн хувьд Авлага үүснэ)
- E mart нь 1.0 сая ₮ төлбөрийг Сүү ХХК-д төлөх тухай мэдээллийг Банкнд хүргүүлэн заасан хугацаанд төлбөр төлөхөө баталгаажуулна.
- E mart нь 1.0 сая ₮ төлбөрийг заасан хугацаанд Банк дээр байрших Сүү ХХК-ий дансанд шилжүүлнэ

- Сүү ХХК үлдсэн 200 мянган ₮-өөс хүү шимтгэл хасагдаад үлдсэн дүнг хүлээн авна

- E mart болон Сүү ХХК нь Банкны KYC/DD шаардлагуудыг хангасан байх шаардлагатай
- E mart-ийн төлбөр төлөх баталгаажуулалт дээр үндэслэн Банк 800 мянган ₮ (Банк өөрийн бодлогоос хамааран Сүү ХХК-ний авлагын 90-80 хувьд санхүүжилт олгох) санхүүжилтийг Сүү ХХК-ний дансанд нэн даруй шилжүүлнэ
- Банкны зүгээс Сүү ХХК-ний 1.0 сая ₮ авлага дээр барьцааны эрх үүсгэн барьцааны мэдэгдлээ ХХБМБЦМС\*-нд бүртгүүлнэ.
- E mart-аас 1.0 сая ₮ төлбөр төлөгдсөний дараа Банкны зүгээс 800 мянган ₮ + зээлийн хүү шимтгэлийг Сүү ХХК-ний данснаас шүүд суутгана

\* - Хөдлөх хөрөнгийн барьцааны мэдэгдлийг бүртгэх цахим мэдээллийн санд

# НСС-ийн жишээ

## Эргэлтийн хөрөнгийн санхүүжилт Жишээ 3: Худалдан авагч/Борлуулагчийн санхүүжилтийн схем



- Сүү ХХК-ний зүгээс өөрийн худалдан авагч/борлуулагчид нарын талаарх дэлгэрэнгүй мэдээллийг банкинд гаргаж өгнө
- Банкны санхүүжилтийн ачаар Дэлгүүр нь Сүү ХХК-иас илүү их хэмжээний сүү авах боломжтой болно
- Сүү ХХК-ний бэлэн мөнгөний үрсгал/борлуулалт сайжирна – их хэмжээний сүү авбал үнэ хямдруулах боломжтой болно

- Дэлгүүр болон Сүү ХХК нь Банкны KYC/DD шаардлагуудыг хангасан байх шаардлагатай
- Дэлгүүрээс санхүүжилтийн хүсэлт хүлээн авсны дараа Банк (Зээл олгох боломжит харьцаан дээр үндэслэн) 800 мянган ₮ төлбөрийг Сүү ХХК-нд Дэлгүүрийн өмнөөс шүүд шилжүүлнэ
- Банкны зүгээс Дэлгүүрийн ирээдүйд орж ирэх орлого + 1.0 сая ₮ бараа материал + Банкны данс зэрэг дээр барьцааны эрх үүсгэн барьцааны мэдэгдлээ ХХБМБЦМС\*-нд бүртгүүлнэ.
- Дэлгүүр Банкнд 800 мянган ₮ + хүү шимтгэлийн төлбөрийг төлнө. Эсвэл Банк 800 мянган ₮ + хүү шимтгэлийн төлбөрийг Дэлгүүрийн Банкн дээрх данснаас авна.

- Дэлгүүр нь Сүү ХХК-иас нийлүүлсэн сүүг хүлээн авч өөрийн эх үүсвэрээс 200 мянган ₮ төлбөрийг шүүд Сүү ХХК-нд төлөн үлдсэн 800 мянган ₮ дээр Банкнаас санхүүжилт авах хүсэлт гаргана
- Дэлгүүр нь өөрийн борлуулалтын үйл ажиллагаандаа Банкны данс болон POS машиныг ашиглах шаардлагатай.
- Дэлгүүрийн зүгээс заасан хугацаанд 800 мянган ₮ + хүү шимтгэлийн хамт Банкнд төлнө.

\* - Хөдлөх хөрөнгийн барьцааны мэдэгдлийг бүртгэх цахим мэдээллийн санд

## НСС-ийн зах зээлийг хөгжүүлснээр бий болох үр дүн

- ЖДБ эрхлэгч зээлдэгчийг дангаар нь авч үзэж зээл олгох эсэхийг судлах биш – сүлжээнд эзэлж буй байр суурь, бусад оролцогчид, ялангуяа тэргүүлэх **компаний үйл ажиллагаатай холбогдуулан зээл олгох** шийд гарна.
- Ингэснээр ЖДБ эрхлэгчдэд зээл олгоход тулгардаг гол бэрхшээлүүдийг (**барьцаа хөрөнгө, зээлжих зэрэглэл**, бизнесийн үйл ажиллагааны тодорхой бус байдал, эрсдэл, г.м) шийдэх боломжийг олгоно.
- Санхүүгийн байгууллагуудын **чадавх сайжирч**, бизнесийн хамрах хүрээ нэмэгдэн, **шинэ зах зээл, шинэ харилцагчтай болж, зээлийн багцын төрөлжилт сайжиран, ашигт ажиллагаа нэмэгдэнэ.**
- Үр дүнтэй, сайн хөгжсөн нийлүүлэлтийн сүлжээний санхүүжилтийн зах зээл нь **Монгол улсын өртгийн сүлжээний өрсөлдөх чадварыг олон улсын зах зээлд сайжруулах, ЖДБ-үүд ХАА-н компаниудад олгох санхүүжилтийг нэмэгдүүлэх, ГШХО болон дотоодын бэлтгэн нийлүүлэгч нарын хоорондын холбоог сайжруулах замаар ажил эрхлэлт болон эдийн засгийн өсөлтийг**

**Анхаарал тавьсанд баярлалаа!**